

**БУЛГАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2025 ОНЫ 3 САР**

2025-04-07

Булган

2025 оны 3 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **22,7** тэрбум төгрөг буюу 89,0 хувийн, нийт зарлага **18,7** тэрбум төгрөг буюу 52,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **22,7** тэрбум төгрөг буюу **89.0** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 0,6 тэрбум төгрөг буюу 3,0 хувь, урсгал орлого 0,1 тэрбум төгрөгөөр буюу 1,7 хувиар тус тус өссөн байна. Урсгал орлогын гүйцэтгэл **17,0** тэрбум төгрөг буюу **93,0** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл (өссөн дүнгээр)	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт (ӨО-ны мөн үетэй харьцуулсан)	
		жилээр	тайлант үе (өссөн дүнгээр)		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	22,003.2	101,810.0	25,471.9	22,660.3	2,811.6	89.0	657.1	103.0
Урсгал орлого	16,827.6	68,656.7	18,312.9	17,036.5	1,276.4	93.0	208.9	101.2
Татварын орлого	15,627.1	61,271.1	16,552.3	15,945.4	606.9	96.3	318.3	102.0
Татварын бус орлого	1,200.5	7,340.5	1,751.6	1,034.1	717.6	59.0	(166.4)	86.1
Хөрөнгийн орлого	28.8	45.0	9.0	57.0	(48.0)	-	28.2	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого	5,146.8	33,153.4	7,159.0	5,623.8	1,535.2	78.6	477.0	109.3
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	2,379.2	15,258.1	2,685.2	1,150.0	1,535.2	42.8	(1,229.2)	48.3
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2,767.6	17,895.3	4,473.8	4,473.8	-	100.0	1,706.2	161.6

Нийт орлогын 24,8 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 70,4 хувийг татварын орлого, 4,8 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 6,4 тэрбум төгрөг буюу татварын орлогын 40,2 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **9,2** тэрбум төгрөг буюу **91,9** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2025 он төлөв.	2025 он 3 сар төлөв.	2025 он 3 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	758.2	131.8	155.7	-23.9	118.1
2	Баяннуур	611.7	160.5	115.8	44.7	72.1
3	Бугат	750.4	121.2	164.3	-43.1	135.6
4	Булган	10134.1	2369	2587.7	-218.7	109.2
5	Бүрэгхангай	2049.6	401.7	482.9	-81.2	120.2
6	Гурванбулаг	802.7	130.1	170.9	-40.8	131.4
7	Дашинчилэн	781.4	223.9	150.2	73.7	67.1
8	Могод	712.6	156.7	145.5	11.2	92.9

9	Орхон	1009.8	196.9	232	-35.1	117.8
10	Рашаант	1644.8	394.6	423.6	-29	107.3
11	Сайхан	739.2	111.5	199.8	-88.3	179.2
12	Сэлэнгэ	857.2	184.1	201.6	-17.5	109.5
13	Тэшиг	1316.1	278.8	350.2	-71.4	125.6
14	Хангал	4303.6	1045.3	1435.1	-389.8	137.3
15	Хишиг-Сндер	811.1	243.7	174.2	69.5	71.5
16	Хутаг-Сндер	1744.2	492.4	454.7	37.7	92.3
17	Хялганат	953.3	230.8	252.9	-22.1	109.6
	СУМЫН ДҮН	29,980.0	6,873.0	7,697.1	-824.1	112.0
18	Аймгийн орлого	35,031.5	10,478.6	8,890.2	1588.4	84.8
	НИЙТ ОРЛОГО	65,011.5	17,351.6	16,587.3	764.3	95.6

Аймгийн дүнгээр авч үзвэл цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, галт зэвсэг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, малд ногдуулах албан татвар, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлого биелсэн байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган аймагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гадаад зээлийн эргэн төлөлтийг орон нутгийн өмчит Булган мээж ХХК, Тэшиг ус ХХК-иуд эргэн төлөх чадваргүй байгаагаас зээлийн хүүгийн орлого тасарч байна. 12 сумын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1150,0 сая төгрөгийн шилжүүлэг ирснээс сумдын Орон нутгийн хөгжлийн санд 736,5 сая төгрөгийг олголоо.

2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **18,7** тэрбум төгрөг буюу **52,2** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **14,7** тэрбум төгрөг буюу **47,4** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **3,9** тэрбум төгрөг буюу **83,9** хувь байна.

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 297,0 сая төгрөг буюу 37,4%, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 87,4 сая төгрөг буюу 3,7%, Замын сангийн гүйцэтгэл 3,2 сая төгрөг буюу 2% байна.

3. Төсвийн өглөг, авлага

Тайлант хугацаанд төсвийн байгууллагууд өр, авлага мэдээлээгүй байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС